



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.29 № 03/2210

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1124 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн НХААГ/20240101595 дугаартай "Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хорооны гэр хорооллын дахин төлөвлөлтийн А болон Б хэсгийн цахилгаан хангамж (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13, 14 дүгээр хороо)"-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлт ирүүлсний дагуу дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

№	Сонирхогч этгээдийн тодруулга	Тодруулгын хариу
1	<p>1. Тендерт оролцогчийн үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сүүлийн сар төлсөн байх шаардлагатай эсэх?</p> <p>2. Хэмжилт, туршилт тохируулгын инженер нь механик инженер байж болох уу? өөр ямар нэг дүйцүүлж болохуйц мэргэжил байгаа юу?</p> <p>3. ТББ-д заасны дагуу ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь 2024 оны 12 сарын 31-ний өдөр гэж заасан нь баталгаатай юу</p>	<p>Хариулт 1: ТШЗ 19.2. в) Тендерт оролцогчийн үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. -Тухайн инженер, техникийн ажилтны ажлын туршлагыг баталгаажуулахын тулд шаардагдсан жилийн нийгмийн даатгал төлсөн цахим тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>Хариулт 2: ТШЗ 19.1. 1.Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: "Шаардана" Үүнд: Хэмжилт, туршилт тохируулгын инженер-1, Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага 3 болон түүнээс дээш жил байна. Хэмжилт, туршилт тохируулгын инженер мэргэжилтэй байна. б) Ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. (Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-д ажилтны дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатайг анхаарна уу.) Монгол улсын Боловсрол, Шинжлэх ухааны</p>

		<p>сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар батлагдсан Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай тушаалын нэгдүгээр хавсралтад заасан Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индекс заасны дагуу үнэлгээнд харгалзан үзнэ.</p> <p>Хариулт 3: ТШЗ 19.2.</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: “Шаардана”</p> <p>1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлэх ба ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байна.</p>
2	<p>Уг нээлттэй сонгон шалгаруулах тендерийн ТШЗ 19.3-т зааснаар ЭХЯ-ны олгодог ТЗ-2.3: 0,4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөл шаардсан байна.</p> <p>Энэхүү заалт нь шударга өрсөлдөөний хязгаарлаж байна гэж үзэж байна.</p> <p>Учир нь ажлын зурагтай танилцахад энэхүү ажил нь бүхэлдээ 10 кВ-ын хүчдэлийн түвшний ажил тул, ТЗ-2,2 буюу 0,4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй компаниудад оролцох боломжтой гэж үзэж байгаа тул тодруулга гаргаж өгнө үү</p>	<p>Тус ажлын үнэлгээний хорооны хурлаар тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж дараах байдлаар шийдвэрлэсэн болно. Үүнд.</p> <p>ТШЗ 19.3.</p> <p>Тусгай зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ.</p> <p>Эрчим хүчний яамны олгодог: ТЗ-2.3: 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ.</p>



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.11.29 12:57